БАГАНУУР ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

Танаа

# БАГАНУУР ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

## /2015 оны эхний 4 сар/

/албан ёсны статистик мэдээллээр бэлтгэсэн танилцуулга/

2015 он

## ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

### Хүснэгт 1. 2014 оны жилийн эцсийн байдлаар

| Үзүүлэлт | Хэмжих нэгж | 1 хороо | 2 хороо | 3 хороо | 4 хороо | 5 хороо | Дүүргийн дүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| Өрхийн тоо | Тоо | 2416 | 215 | 2292 | 1369 | 1980 | 8272 |
| Суурин хүн ам | Тоо | 8200 | 641 | 8104 | 5030 | 6358 | 28333 |
| Үүнээс: эрэгтэй | Тоо | 3924 | 325 | 3922 | 2495 | 3163 | 13829 |
| эмэгтэй | Тоо | 4276 | 316 | 4182 | 2535 | 3195 | 14504 |
| Малын тоо | Тоо | 40511 | 8476 | 36937 | 41239 | 21960 | 149123 |
| Үүнээс: Тэмээ | Тоо | 107 | - | 2 | 1 | - | 110 |
| Адуу | Тоо | 3353 | 498 | 2302 | 2670 | 2114 | 10937 |
| Үхэр | Тоо | 3213 | 1043 | 2516 | 2579 | 1740 | 11091 |
| Хонь | Тоо | 20412 | 4046 | 20533 | 21515 | 10931 | 77437 |
| Ямаа | Тоо | 13426 | 2889 | 11584 | 14474 | 7175 | 49548 |

### Хүснэгт 2. Жил бүрийн тайлант хугацаанд

| Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2008 | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Суурин хүн ам | Тоо | 25877 | 25875 | 26905 | 27036 | 27440 | 27936 | 28333 | |
| Төрөлт | Тоо | 260 | 245 | 218 | 199 | 220 | 272 | 263 | 247 |
| Нас баралт | Тоо | 72 | 56 | 53 | 59 | 49 | 62 | 58 | 66 |
| Шилжиж ирсэн | Тоо | 374 | 307 | 503 | 252 | 304 | 461 | 338 | 324 |
| Шилжиж явсан | Тоо | 571 | 474 | 543 | 253 | 377 | 447 | 282 | 391 |
| Ажилгүйчүүд | Тоо | 304 | 498 | 751 | 585 | 498 | 374 | 325 | 471 |
| Халдварт өвчин | Тоо | 252 | 221 | 168 | 204 | 186 | 229 | 125 | 266 |
| Бүртгэгдсэн гэмт хэрэг | Тоо | 118 | 99 | 97 | 86 | 108 | 99 | 86 | 102 |

АЖ ҮЙЛДВЭР: Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт 2015 оны эхний 4 сарын байдлаар 35.6 тэр бум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 10.2 хувиар буюу 3.3 тэр бум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт

| Үзүүлэлт | Нийт үйлдвэрлэлт /биет хэмжээгээр/ | | | Нийт үйлдвэрлэлт /үнийн дүнгээр, мянган төгрөг/ | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2014 он | 2015 он | өсөлт бууралт | 2014 он | 2015 он | өсөлт бууралт |
| Нүүрс олборлолт | 1357.1 | 1310.5 | -46.6 | 30534750.0 | 33417750.0 | 2883000.0 |
| Дулаан дамжуулалт | 80.3 | 74.1 | -6.2 | 1551110.4 | 2017363.1 | 466252.7 |
| Талх үйлдвэрлэлт | 25.7 | 35.5 | 9.8 | 33097.7 | 44311.9 | 11214.2 |
| Нарийн боов үйлдвэрлэлт | 48.6 | 58.9 | 10.3 | 114460.7 | 144291.8 | 29831.1 |

Зураг 1. Нүүрс олборлолт /сараар/




Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт /биет хэмжээгээр/ өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нарийн боов үйлдвэрлэлт 21.2 хувиар буюу 10.3 тонноор, талх үйлдвэрлэлт 38.1 хувиар буюу 9.8 тонноор өссөн бол дулаан дамжуулалт 7.7 хувиар буюу 6.2 мянган гкал, нүүрс олборлолт 3.4 хувиар буюу 46.6 мянган тонноор тус тус буурсан байна.

Харин аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт /үнийн дүнгээр/ өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нүүрс олборлолт 9.4 хувиар буюу 2.8 тэр бум төгрөгөөр, дулаан дамжуулалт 30 хувиар буюу 466.2 сая төгрөгөөр, нарийн боов үйлдвэрлэлт 26.1 хувиар буюу 29.8 сая төгрөгөөр, талх үйлдвэрлэлт 33.8 хувиар буюу 11.2 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Зураг 2. Талх, нарийн боов үйлдвэрлэлт, тонн




Зураг 3. Нүүрс олборлолт /мян.тонн/



НИЙГМИЙН ДААТГАЛ: Тайлант хугацаанд нийгмийн даатгалын сангийн орлого 3495.0 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 20.0 хувиар буюу 582.1 сая төгрөгөөр, зарлага 6343.2 сая төгрөг болж 17.3 хувиар буюу 934.1 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Зураг 4. Нийгмийн даатгалын сангийн орлого




Нийт орлогын 61.5 хувь буюу 2147.0 сая төгрөгийг тэтгэврийн сангаас, 6.9 хувь буюу 241.0 сая төгрөгийг тэтгэмжийн сангаас, 1.7 хувь буюу 59.2 сая төгрөгийг ажилгүйдлийн сангаас, 10.8 хувь буюу 379.5 сая төгрөгийг ҮОМШӨ сангаас, 19.1 хувь буюу 668.3 сая төгрөг нь эрүүл мэндийн даатгалын сангаас тус тус төвлөрсөн байна.

Хүснэгт 4. Нийгмийн даатгалын сангийн орлого, зардал

| Үзүүлэлт | 2014 он | | 2015 он | |
|---|---|---|---|---|
| | Хүний тоо | Сая төгрөг | Хүний тоо | Сая төгрөг |
| Сангийн орлого бүгд | | 2912.9 | | 3495.0 |
| үүнээс: тэтгэврийн сан | | 1792.7 | | 2147.0 |
| тэтгэмжийн сан | | 200.5 | | 241.0 |
| ажилгүйдлийн сан | | 49.0 | | 59.2 |
| ҮОМШӨ-ний сан | | 315.3 | | 379.5 |
| ЭМД-ын сан | | 555.4 | | 668.3 |
| Сангийн зарлага бүгд | 39448 | 5409.1 | 40311 | 6343.2 |
| үүнээс: тэтгэврийн сан | 3496 | 3491.0 | 3751 | 4332.0 |
| тэтгэмжийн сан | 963 | 238.4 | 939 | 250.6 |
| ажилгүйдлийн сан | 64 | 57.8 | 73 | 72.7 |
| ҮОМШӨ-ний сан | 460 | 578.9 | 447 | 578.0 |
| ЭМД-ын сан | 34465 | 1043.0 | 35101 | 1109.9 |

Зураг 5. Нийгмийн даатгалын сангийн зарлага /хувиар/




Тайлант хугацаанд нийгмийн даатгалын сангаас 3751 хүнд 4332.0 сая төгрөгийн тэтгэвэр, 939 хүнд 250.6 сая төгрөгийн тэтгэмж, 73 хүнд 72.7 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж, 447 хүнд 578.0 сая төгрөгийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэмж, 35101 хүнд 1109.9 сая төгрөгийн эрүүл мэндийн даатгал олгосон байна.

НИЙГМИЙН ХАЛАМЖ: 2015 оны эхний 4 сарын байдлаар нийгмийн халамжийн сангийн орлого 907.8 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 1.8 хувиар буюу 17.4 сая төгрөгөөр буурсан байна.

Нийт орлогын 315.0 сая төгрөг буюу 34.7 хувь нь улсын төсвөөс, 591.7 сая төгрөг буюу 65.2 хувь нь орон нутгийн төсвөөс, 1.1 сая төгрөг буюу 0.1 хувь нь бусад орлогоор тус тус санхүүжигдсэн байна.




Зураг 6. Нийт орлого 907.8 сая төгрөг

Хүснэгт 5. Нийгмийн халамжийн сангийн орлого, зардал

| Үзүүлэлт | | 2014 он | | 2015 он | |
|---|---|---|---|---|---|
| | | Мян төг | Хүний тоо | Мян төг | Хүний тоо |
| Нийгмийн халамжийн сангийн орлого | | 925172.9 | | 907820.0 | |
| Үүнээс: | Улсын төсвөөс | 304800.0 | | 315000.0 | |
| | Орон нутгийн төсвөөс | 620038.0 | | 591752.7 | |
| | Бусад орлого | 334.9 | | 1067.3 | |
| Нийгмийн халамжийн сангийн зарлага | | 851744.6 | | 814039.3 | |
| Үүнээс: | Тэтгэвэр | 245199.2 | 537 | 236467.8 | 523 |
| | Тэтгэмж | 104250.4 | 348 | 106054.6 | 417 |
| | "Алдарт эх" 1 одонтой эхчүүд | 148800.0 | 744 | 147600.0 | 738 |
| | "Алдарт эх" 2 одонтой эхчүүд | 119000.0 | 1190 | 124000.0 | 1240 |
| | Жирэмсэн эхчүүдийн тэтгэмж | 122584.4 | 775 | 107583.9 | 871 |
| | Ахмад дайчин, гавьяатын нэмэгдэл | 13719.6 | 22 | 18440.0 | 20 |
| | Ахмад настанд үзүүлсэн хөнгөлөлт | 63510.1 | 1592 | 48939.3 | 254 |
| | ХБИргэнд үзүүлсэн хөнгөлөлт | 15761.3 | 88 | 18797.0 | 119 |
| | ОНО-д түшиглэсэн халамжийн үйлчилгээ | 12633.6 | 551 | 3936.0 | 36 |
| | Бусад үйлчилгээ | 6286.0 | | 2220.7 | |

Тайлант хугацаанд нийгмийн халамжийн сангаас 523 хүнд 236.5 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, 417 хүнд 106.1 сая төгрөгийн тэтгэмж, "Алдарт эх"-ийн одонтой 1978 хүнд 271.6 сая төгрөг, 871 жирэмсэн эхчүүдэд 107.6 сая төгрөгийн тэтгэмж, 20 ахмад дайчин, гавъяат цолтой хүнд 18.4 сая төгрөг, 254 ахмад настанд 49.0 сая төгрөгийн хөнгөлөлт, 119 хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 18.8 сая төгрөгийн хөнгөлөлт, ОНО-д түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 36 иргэд 3.9 сая төгрөгийг тус тус олгосон байна.

НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ: Тайлант хугацаанд нийтийн аж ахуй үйлчилгээний салбарын нийт орлого 567.7 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үеийнхээс 40.8 хувиар буюу 164.5 сая төгрөгөөр өссөн байна. Нийт орлогын 361.2 сая төгрөг буюу 63.6 хувь нь хүн амаас оруулсан орлого ээлж байна.

Зураг 7. Орлогын төлөвлөгөөний биелэлт




Хүснэгт 6. Орон сууц нийтийн аж ахуйн орлогын байдал. мянган төгрөг

| Үзүүлэлт | 2014 он | 2015 он | Өсөлт бууралт |
|---|---|---|---|
| Орон сууц | 112274.2 | 48514.0 | -63760.2 |
| Ус борлуулалт-бүгд | 145839.7 | 264881.2 | 119041.5 |
| үүнээс: хүн амд | 94335.2 | 158392.4 | 64057.2 |
| аж ахуйн нэгжид | 49949.1 | 100981.4 | 51032.3 |
| үйлчилгээний байгууллагад | 1555.4 | 5507.4 | 3952.0 |
| Сувагжуулалт | 132593.9 | 213446.1 | 80852.2 |
| Бусад | 12502.8 | 40929.4 | 28426.6 |
| Дүн | 403200.7 | 567770.7 | 164570.0 |

СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ХОЛБОО: 2015 оны эхний 4 сарын байдлаар дүүргийн сууц өмчлөгчдийн холбоодын орлогын төлөвлөгөөний биелэлт доорх байдалтай байна.

Хүснэгт 7. Сууц өмчлөгчдийн холбоодын орлогын байдал. мянган төгрөг

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | ТБ% |
|---|---|---|---|
| Тавлаг өргөө | 21581.3 | 20507.6 | 95.0 |
| Маргад өргөө | 17960.0 | 13826.8 | 77.0 |
| Сод хөгжил | 21536.6 | 17920.6 | 83.2 |
| Шинэ элч | 20189.2 | 14762.6 | 73.1 |
| Уурхайчин | 17136.0 | 13158.7 | 76.8 |
| НИЙТ ДҮН | 98403.1 | 80176.3 | 81.0 |

ЭРҮҮЛ МЭНД: Дүүрэгт эхний 4 сарын байдлаар 256 эх амаржиж, 256 хүүхэд төрүүлснээс гадны 45 эх амаржсан байна. Энэ хугацаанд 42741 хүн амбульторын үзлэгт хамрагдсан нь өнгөрсөн оны мөн үеэс 7451 хүнээр буюу 21.1 хувиар, 2549 хүн хэвтэн эмчлүүлсэн байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 270 хүнээр буюу 11.8 хувиар тус тус өссөн байна.

Зураг 8. Халдварт өвчин /сараар/



Хүснэгт 8. Бүртгэгдсэн халдварт өвчин

| Үзүүлэлт | | 2014 он | 2015 он | Өсөлт бууралт |
|---|---|---|---|---|
| Халдварт, паразит өвчин | | 79 | 115 | 36 |
| үүнээс: | Заг хүйтэн | 24 | 51 | 27 |
| | Тэмбүү | 30 | 36 | 6 |
| | Трихомноз | 19 | 24 | 5 |
| | Мөөгөнцөр | 6 | 2 | -4 |
| | Кандилом | - | 2 | 2 |
| Цочмог халдварт өвчин | | 46 | 151 | 105 |
| үүнээс: | Цусан суулга | 2 | 1 | -1 |
| | Гепатит А | 3 | 4 | 1 |
| | Салхин цэцэг | 26 | 127 | 101 |
| | Гахай хавдар | 2 | 1 | -1 |
| | Гар хөл амны өвчин | 3 | - | -3 |
| | Корь | - | 2 | 2 |
| | Сепсис | - | 2 | 2 |
| | Хачигт рикеттиоз | - | 1 | 1 |
| | Боом | - | 1 | 1 |
| | Сүрьеэ | 10 | 12 | 2 |
| Нийт халдварт өвчин | | 125 | 266 | 141 |

2015 оны эхний 4 сарын байдлаар халдварт паразит өвчин 115 болж нийт халдварт өвчний 43.2 хувийг эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 36 тохиолдлоор буюу 45.5 хувиар, цочмог халдварт өвчин 151 тохиолдол байгаа нь нийт халдварт өвчний 56.8 хувийг эзэлж, өнгөрсөн оны мөн үеэс 105 тохиолдлоор буюу 2.3 дахин тус тус өссөн байна. Дүүргийн дунджаар 10000 хүн тутамд ногдох халдварт өвчнөөр өвчлөгсдийн тоо 94.5 байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 49.4 продицмиллээр өссөн байна.

ГЭМТ ХЭРЭГ: 2015 оны эхний 4 сарын байдлаар дүүрэгт 102 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 18.6 хувиар буюу 16 хэргээр өссөн байна. Хэрэг илрүүлэлт 68 хувь болж өнгөрсөн оны мөн үеэс 4.2 пунктээр буурсан байна.

Зураг 9. Бүртгэгдсэн гэмт хэрэг /сараар/




Хүснэгт 9. Бүртгэгдсэн гэмт хэрэг

| Хэргийн төрөл | Хэргийн тоо | | Хэргийн өсөлт | Дунд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| | 2014 он | 2015 он | | |
| Хүн амь | - | 1 | 1 | 0.9 |
| Хүчин | 1 | 1 | - | 0.9 |
| Дээрэм | 3 | 1 | -2 | 0.9 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Танхай | 4 | 4 | - | 3.9 |
| ББМГУчруулах | 42 | 50 | 8 | 49 |
| Ашиглах | - | 2 | 2 | 1.9 |
| Хулгай | 13 | 20 | 7 | 19.6 |
| *үүнээс: малын* | *1* | *1* | - | *0.5* |
| Булаалт | - | - | - | - |
| Залилан | - | 1 | 1 | 0.9 |
| ХАБЭсрэг | 7 | 4 | -3 | 3.9 |
| Гал түймэр | - | - | - | - |
| Бусад | 16 | 18 | 2 | 17.6 |
| Бүгд | 86 | 102 | 16 | 100.0 |
| Хэрэг илрүүлэлт | 72.2% | 68% | | |

*-малын хулгайн хэргийг нийт хулгайн хэрэгт эзлэх хувиар тооцсон.

Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 0.9 хувийг хүн амь, 3.9 хувийг танхай хэрэг, 49.0 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах /ББМГУчруулах/ хэрэг, 1.9 хувийг ашиглах хэрэг, 0.9 хувийг дээрэм, 19.6 хувийг хулгай хэрэг, 0.9 хувийг залилангийн хэрэг, 3.9 хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг /ХАБЭ/ гэмт хэрэг, 0.9 хувийг хүчингийн хэрэг, 17.6 хувийг бусад хэрэг тус тус эзэлж байна. Тайлант хугацаанд булаалт, болон гал түймрийн хэргүүд бүртгэгдээгүй байна.

Хүснэгт 10. Гудамж талбайд болон согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг

| Хэргийн төрөл | 2014 он | | 2015 он | |
|---|---|---|---|---|
| | согтуугаар | гудамж талбайд | согтуугаар | гудамж талбайд |
| Хүчин | - | 1 | - | - |
| Дээрэм | 3 | 1 | 1 | - |
| Танхай | 4 | 1 | 2 | 2 |
| ББМГУчруулах | 23 | 10 | 29 | 11 |
| Хулгай | 1 | - | - | 4 |
| Залилан | - | - | - | - |
| ХАБЭсрэг | 2 | - | 2 | 0 |
| Хүний амь | - | - | 1 | 1 |
| Бусад | 4 | 4 | 5 | 3 |
| Бүгд | 37 | 17 | 40 | 21 |
| Дүнд эзлэх хувь | 43.0 | 19.8 | 39.2 | 20.5 |

2015 оны 4 сарын байдлаар согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 40 болж өнгөрсөн оны мөн үеэс 8.1 хувиар буюу 3 хэргээр өссөн байна. Энэ нь тайлант хугацаанд бүртгэгдсэн гэмт хэргийн 39.2 хувийг эзэлж байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 3.8 пунктээр буурсан байна. Мөн гудамж талбайд үйлдэгдсэн хэргийн тоо

Зураг 10. Согтуугаар болон гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг



21 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 23.5 хувиар буюу 4 хэргээр өсч, нийт гэмт хэргийн 20.5 хувийг эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 0.7 пунктээр өссөн байна.

АЖИЛ ЭРХЛЭЛТ: 2015 оны 4 сарын байдлаар дүүрэгт ажил идэвхитэй хайж байгаа ажилгүй иргэд 471 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 45.0 хувиар буюу 146 хүнээр, эмэгтэй ажилгүй иргэд 315 байгаа нь өмнөх оны мөн үеэс 79.0 хувиар буюу 139 хүнээр тус тус өссөн байна. Идэвхтэй ажил хайж байгаа 20 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаагаас 9 иргэн буюу 45.0 хувь эмэгтэй байна.

Зураг 11. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн хөдөлгөөн




Тайлант сард ажил идэвхтэй хайж байгаа 129 иргэн шинээр бүртгүүлсэн бөгөөд үүний 54.3 хувь нь буюу 70 нь эмэгтэйчүүд байна. Мөн энэ хугацаанд 28 иргэн ажилд зуучлуулан орсон байна.

- Бүртгэлтэй ажилгүй иргэдийн ажилд орсон байдлыг авч үзэхэд:
- хязгаарлагдмал хариуцлагатай компанид – 6
- төсөвийн байгууллагад – 4
- төрийн бус байгууллагад – 18 иргэн тус тус ажилд орсон байна.

Хүснэгт 11. Ажилгүй иргэд, насны ангилалаар

| Үзүүлэлт | 2014 он | Дунд эзлэх хувь | 2015 он | Дунд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| 16-24 нас | 81 | 25.0 | 105 | 22.3 |
| 25-34 нас | 108 | 33.2 | 205 | 43.5 |
| 35-44 нас | 75 | 23.1 | 95 | 20.2 |
| 45-60 нас | 61 | 18.7 | 66 | 14.0 |
| Бүгд | 325 | 100.0 | 471 | 100.0 |

2015 оны 4 сарын байдлаар ажил идэвхтэй хайж байгаа бүртгэлтэй ажилгүй иргэдийг насны ангиллаар авч үзэхэд 22.3 хувь нь 16-24 насны, 43.5 хувь нь 25-34 насны, 20.2 хувь нь 35-44 насны, 14.0 хувь нь 45-60 насны ажилгүй иргэд эзэлж байна.

Хүснэгт 12. Ажилгүй иргэд, боловсролоор

| Үзүүлэлт | | Ажилгүй иргэд | | Бүгдэд эзлэх хувь | |
|---|---|---|---|---|---|
| | | 2014 он | 2015 он | 2014 он | 2015 он |
| Бүртгэлтэй ажилгүй иргэд | | 325 | 471 | 100.0 | 100.0 |
| Үүнээс | Дээд | 97 | 155 | 29.8 | 32.9 |
| | Тусгай дунд | 23 | 42 | 7.1 | 8.9 |
| | Мэргэжлийн анхан шатны | 21 | 40 | 6.5 | 8.5 |
| | Бүрэн дунд | 145 | 199 | 44.6 | 42.2 |
| | Бүрэн бус дунд | 26 | 25 | 8.0 | 5.3 |
| | Бага | 4 | 5 | 1.2 | 1.1 |
| | Боловсролгүй | 9 | 5 | 2.8 | 1.1 |

Зураг 12. Бүртгэлтэй ажилгүй иргэд /боловсролоор/




2015 оны 4 сарын байдлаар ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийг боловсролын түвшингээр ангилж үзэхэд 32.9 хувийг дээд, 8.9 хувийг тусгай дунд, 8.5 хувийг мэргэжлийн анхан шатны, 42.2 хувийг бүрэн дунд, 5.3 хувийг бүрэн бус дунд, 1.1 хувийг бага боловсролтой 1.1 хувийг боловсролгүй ажилгүй иргэд эзэлж байна.

ҮНЭ ХАНШ: 2015 оны 4 сарын хүнсний өргөн хэрэглээний 19 нэр төрлийн бүтээгдэхүүний дундаж үнийг ажиглахад доорх байдалтай байна.

Хүснэгт 13. Хүнсний барааны үнийн ажиглалт, 2015 оны 4 сарын дундаж үнэ

| № | Хүнсний бараа | | х.н | Хишиг-Уул супермаркет | Марал хүнсний дэлгүүр | Хэрлэн хүнсний зах | B&M супермаркет | Шинэ хүнсний зах |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | "Алтан тариа" гурил | Дээд | кг | 1463 | 1400 | - | 1500 | 1400 |
| | | I зэрэг | кг | 1100 | 1100 | - | 1100 | 1200 |
| | | II зэрэг | кг | 900 | 900 | - | 900 | 900 |
| 2 | Будаа | цагаан | кг | 2425 | 2175 | - | 2200 | 2375 |
| | | шар | кг | 1725 | 1800 | - | 1700 | 1700 |
| 3 | Хонины мах | ястай | кг | - | - | 7675 | - | 7500 |
| | | цул | кг | - | - | 8125 | - | 8500 |
| 4 | Үхрийн мах | ястай | кг | - | - | 8625 | - | 8500 |
| | | цул | кг | - | - | 10000 | - | 10500 |
| 5 | Адууны мах, ястай | | кг | - | - | 7000 | - | 7000 |
| 6 | Ямааны мах | | кг | - | - | 7375 | - | 7500 |
| 7 | Элсэн чихэр | | кг | 1638 | 1600 | - | 1500 | 1700 |
| 8 | Сүү | | л | 1287 | - | - | - | - |
| 9 | Тараг | | л | 1800 | - | - | - | - |
| 10 | Цөцгийн тос, Орос | | кг | 3325 | 3400 | - | 3450 | - |
| 11 | Байцаа | | кг | - | - | 1200 | 1350 | 1200 |
| 12 | Манжин | | кг | - | - | 1800 | 1950 | 1775 |
| 13 | Төмс | монгол | кг | - | - | 1350 | 1213 | 1375 |
| 14 | Лууван | монгол | кг | - | - | 1200 | 1175 | 1200 |
| 15 | Сонгино | хятад | кг | - | - | 1200 | 1250 | 1225 |
| | | монгол | кг | - | - | 2075 | | 2025 |
| 16 | Сармис, булцуу | | кг | - | - | 295 | | 300 |
| 17 | Огурцы, хятад | | кг | - | - | 5000 | 4000 | 4500 |
| 18 | Помидор, хятад | | кг | - | - | 5000 | 5500 | 5375 |
| 19 | Ургамлын тос/ sunny gold/ | | ш | 3438 | 3450 | - | 3500 | 3500 |
| 20 | Өндөг | | ш | 300 | 290 | - | 300 | 300 |
| 21 | Талх | бурна том 900 гр | ш | 1400 | 1400 | - | 1400 | 1400 |
| | | бурна Дунд 700 гр | ш | 1100 | 1100 | - | 1100 | 1000 |
| | | бурна жижиг 500 гр | ш | 950 | 950 | - | 950 | 950 |
| | | Есөн шанд /жижиг/ | ш | 1000 | 1000 | - | 950 | 950 |
| | | Атар талх | ш | 1000 | 1000 | - | 1100 | 1100 |

Зураг 13. "Алтан тариа" гурилын үнэ / жил бүрийн 4 сар/




Зураг 14. Нэг кг махны үнэ /жил бүрийн 4 сар/




Хүснэгт 14. Үйлчилгээний үнийн тариф /НӨТ-гүй үнэ/

| Үзүүлэлт | | Айл өрхөд | Аж ахуйн нэгж байгууллагад |
|---|---|---|---|
| Дулаан | | 1 $м^2$=522 төг | $1м^3$=853 төг |
| Дулааны суурь тариф | | 40 $м^2$ хүртлэх=3000 төг | - |
| | | $40м^2$ - $80м^2$ = 5000 төг | |
| | | $81м^2$ –аас дээш = 10000 төг | |
| Халуун ус | Өвөл | 1 хүн=2500 төг /тоолуургүй/<br>$1м^3$=1187 төг /тоолууртай / | 1гкал=54561 төг |
| | Зун | 1 хүн=3500 төг /тоолуургүй/<br>$1м^3$=1187 төг /тоолууртай / | |
| Цэвэр ус* | | 1 хүн=5106 төг /тоолуургүй/ | 1 л=1.20 төг /тоолуургүй/ |
| | | 1 л=0.63 төг /тоолууртай/ | 1 л=1.15 төг /тоолууртай/ |
| | | Суурь хураамж =1800 төг | 1 л=4.41 төг /зөөврөөр/ |
| Бохир ус* | | 1 хүн=4830 төг /тоолуургүй/<br>1 л=0.58 төг /тоолууртай/ | 1 л=1.20 төг /тоолуургүй/<br>1 л=1.15 төг/тоолууртай/ |

**2015 оны 1 сарын 10-наас мөрдөж байгаа тариф*

Хүснэгт 15. Цахилгааны үнийн тариф /НӨТ-гүй үнэ/

| Хэрэглэгчдийн ангилал | Хэмжих нэгж | Тариф /НӨАТ-гүй/ |
|---|---|---|
| ❋ ***Айл өрхөд борлуулах цахилгааны тариф*** | | |
| Энгийн тоолууртай | | |
| Сарын нийт хэрэглээний 150 кВт.ц | төг/квт.ц | 84.0 |
| Сарын нийт хэрэглээний 151 кВт.ц-аас дээш | төг/квт.ц | 101.6 |
| **2 тарифт тоолууртай** | | |
| Өдрийн хэрэглээ /06.00-21.00/ | төг/квт.ц | 89.0 |
| Орой, шөнийн хэрэглээ /21.00-06.00/ | төг/квт.ц | 65.0 |
| **Сарын суурь тариф** | төг/сар | 1000.0 |
| ❋ *Аж ахуйн нэгж, байгууллагад борлуулах цахилгааны тариф* | | |
| Энгийн тоолууртай | төг/квт.ц | 110.6 |
| 3 тарифт тоолууртай | | |
| Өдрийн хэрэглээ /06.00-17.00/ | төг/квт.ц | 110.6 |
| Оройн хэрэглээ /17.00-24.00/ | төг/квт.ц | 183.6 |
| Шөнийн хэрэглээ /24.00-06.00/ | төг/квт.ц | 65.0 |

**2014 оны 8 сарын 10-ны өдрөөс мөрдөж буй тариф*

Хүснэгт 16. Түлш шатахууны үнэ

| Шатахууны нэр төрөл | 2011 он | 2012 он | 2013 он | 2014 он | 2015 он | өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хувь | төгрөгөөр |
| АИ -76,80 | 1200 | 1505 | 1570 | 1560 | 1560 | - | - |
| АИ -92,93 | 1352 | 1805 | 1710 | 1700 | 1700 | - | - |
| Дизель түлш | 1376 | 1855 | 1840 | 1830 | 1830 | - | - |

2015 оны 4 сарын байдлаар түлш, шатахууны үнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулж үзэхэд өөрчлөгдөөгүй байна.

Зураг 15. Хот хоорондын зорчигч тээврийн үнэ /УБ-БН, БН-УБ/




СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2015 оны 5 дугаар сарын 8 өдөр